



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

Г Хорооны 2011 оны 73 дугаар тогтоолд 7
нэмэлт оруулах тухай

Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2011 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Гомдлыг хангаж, шийдвэрийг хүчингүй болгох тухай” 12 дугаар тогтоол батлагдсаныг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Банкны тухай хуулийн 6.2.7, 6.4 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 73 дугаар тогтоолын 1 дэх заалтын “зах зээлд” гэсний дараа “харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ” гэж нэмсүгэй.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН